



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 17 өдөр

Дугаар A/512

Булган сум

Г Эрх олгох тухай Г

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, мөн хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2, 34 дүгээр зүйлийн 34.1 дэх заалт, 45 дугаар зүйлийн 45.7 дахь заалт, Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Барилгын хөгжлийн төв, Булган аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын хооронд байгуулсан барилга байгууламжийн ажилд захиалагчийн техник хяналт гүйцэтгүүлэх гэрээний төлбөр 97 279 285 (ерэн долоон сая хоёр зуун далан есөн мянга хоёр зуун наян тав) төгрөгөөр тус газрын kontorын барилгын засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах эрхийг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, журмын хүрээнд Төрийн худалдан авах ажиллагааны [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим системээр зохион байгуулж, гэрээ байгуулан, батлагдсан зураг төсвийн дагуу чанартай гүйцэтгүүлж, өдөр тутмын хяналтыг тавьж хүлээн авахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т үүрэг болгосугай.

3. Гүйцэтгэлийн баримт бичгийн холбогдох хууль тогтоомжийн дагуу үйлдэж Төрийн архивын тасагт эх хувийг материалыг хүлээлгэн өгөх, төрийн болон орон нутгийн өмчид бүртгүүлж ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т үүрэг болгосугай.

4. Эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаанд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж, хяналт тавьж ажиллахыг Худалдан авах ажиллагааны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Баярцэнгэл)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  
Б.АРИУН-ЭРДЭНЭ

6324010875